



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СҮМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 12

Хажуу шинэ-Ус

Хяналтын зөвлөлийг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.2 дахь заалт, 4дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаас **ТОГТООХ нь**:

1. Говь-Угтаал сумын хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хяналтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хяналтын зөвлөлийн дарга: М.Болортuya (ИТХын төлөөлөгч)

Нарийн бичгийн дарга: Д.Сарангэрэл (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл

хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Мөнхбаяр (Аймгийн хоршоо, жижиг дунд үйлдвэрийн асуудал

хариуцсан мэргэжилтэн

Н.Болор-Эрдэнэ (Төрийн сангийн мэргэжилтэн)

Э.Должинсүрэн (Залуучуудын холбооны тэргүүлэгч)

2. Зээлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналтын зөвлөлийн дарга (М.Болортuya)-д даалгасугай

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Булган)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ПҮРЭВСЭНГЭ

